



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОМА-2023/07/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.24 № 278
танай _____-ны № _____-т

МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗАСАГ
ДАРГА Э.МӨНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мандал-Овоо сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал-Овоо сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Мандал-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 7/4 дүгээр “2022 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 283.5 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 274.8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 8.7 сая төгрөгөөр тасалсан байна.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэлд тайланд тусгасан нийт авлагын 81.1 хувь 174.7 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас олгосон чанаргүй, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа нь уг сан хэвийн бус, эрсдэлтэй байгааг харуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээ байхгүй байна.

016020378

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,162,211.2	1,067,877.5
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	554,345.1	622,715.0
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	259,828.1	215,226.2
УРЬДЧИЛГАА	7а, 7б	2,576.0	20,921.7
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	345,462.0	209,014.6
НӨӨЦИЙН БАРАА	9а	0.0	0.0
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	0.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		9,777,913.9	5,792,967.0
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0.0	0.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	9,777,913.9	5,792,967.0
Газар		0.0	0.0
Биет хөрөнгө		9,737,634.8	5,634,105.8
Биет бус хөрөнгө	13	40,279.0	158,861.3
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		10,940,125.1	6,860,844.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,019,818.0	2,330,029.5
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	278,146.8	268,825.3
Өглөг	17а, 17б	276,972.6	268,825.2
Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,174.2	0.1
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,741,671.1	2,061,204.2
Урт хугацаат зээл	20а, 20б	1,741,671.1	2,061,204.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		8,920,307.1	4,530,815.0
Засгийн газрын хувь оролцоо		8,920,307.1	4,530,815.0
Засгийн газрын оруулсан капитал		3,339,562.4	1,329,697.9
Улсын төсвийн оруулсан хөрөнгө		0.0	0.0
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		3,339,562.4	1,329,697.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		152.0	152.0
Хуримтлагдсан үр дүн		4,269,629.4	2,847,876.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,310,963.3	353,088.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		10,940,125.1	6,860,844.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		6,206,679.4	1,714,859.8
ТАТВАРЫН ОРЛОГО		152,569.0	271,444.1
Орлогын албан татвар		112,035.3	155,259.7
Хувь хүний орлогын албан татвар		112,035.3	161,098.6
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-5,838.9
Хөрөнгийн албан татвар		1,230.0	35,456.7
Бусад татвар, төлбөр, хураамж		39,303.8	80,727.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,261,507.0	686,103.9
Нийтлэг татварын бус орлого		1,261,507.0	686,103.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,792,603.4	757,311.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	5,378,748.0	1,231,188.3
УРСГАЛ ЗАРДАЛ		5,378,748.0	1,231,188.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,421,791.4	1,201,841.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,042,280.8	239,476.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		133,505.7	30,166.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		237,451.0	254,738.7
Хангамж, бараа материалын зардал		104,194.9	55,088.7
Нормативт зардал		137,572.2	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал		37,647.2	4,826.0
Томилолт, зочны зардал		4,705.0	5,415.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		140,955.9	139,072.7
Бараа үйлчилгээний бусад зардал		2,583,478.8	473,056.8
ХҮҮ		0.0	0.0
ТАТААС		0.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		956,956.7	29,347.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		827,931.4	483,671.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		239,856.1	712,781.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		588,075.3	-229,110.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	8,920,307.1	0.0	8,920,307.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,160,382.1	0.0	-4,160,382.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,759,925.0	0.0	4,759,925.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-229,110.0	0.0	-229,110.0
2022 оны 12-р сарын 31-аарх үлдэгдэл	4,530,815.0	0.0	4,530,815.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,432,765.3	1,359,549.8
ТАТВАРЫН ОРЛОГО	152,569.0	271,496.0
Орлогын албан татвар	112,035.3	155,311.6
Хувь хүний орлогын албан татвар	112,035.3	161,150.5
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-5,838.9
Хөрөнгийн албан татвар	1,230.0	35,456.7
Бусад татвар, төлбөр, хураамж	39,303.8	80,727.7
Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,458.6	16,389.7
Газрын төлбөр	245.7	5,729.7
Байгалийн нөөц ашигласны төлбөр	26,599.4	58,608.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	506,617.0	330,742.0
Нийтлэг татварын бус орлого	506,617.0	330,742.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,773,579.2	757,311.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,984,145.7	1,282,079.9
УРСГАЛ ЗАРДАЛ	4,984,145.7	1,282,079.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,029,343.3	1,063,927.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,134,467.2	340,127.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,379.8	62,427.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	258,685.2	281,137.1
Хангамж, бараа материалын зардал	222,556.4	176,658.0
Нормативт зардал	142,817.1	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	19,565.0	4,826.0
Томилолт, зочны зардал	4,705.0	5,415.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,768.2	126,335.5
Бараа үйлчилгээний бусад зардал	1,935,399.4	67,000.3
ХҮҮ	0.0	0.0
ТАТААС	0.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	954,802.5	218,152.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	448,619.5	77,470.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	248,583.1	9,100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	248,583.1	9,100.0
Дотоод эх үүсвэрээр	248,583.1	9,100.0
Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-248,583.1	-9,100.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	0.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	200,036.4	68,370.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	354,308.6	554,345.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	554,345.1	622,715.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,152,833.8	865,568.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1,152,833.8	865,568.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	802,287.3	651,559.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,726.4	237,907.6
Үндсэн цалин	225,922.4	205,818.2
Нэмэгдэл	51,244.0	31,589.4
Унаа хоолны хөнгөлөлт	-	21.8
Урамшуулал	7,560.0	423.9
Гэрээт ажлын хөлс	-	54.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,066.1	30,214.7
Тэтгэврийн даатгал	24,078.7	21,006.5
Тэтгэмжийн даатгал	2,750.0	2,327.2
ҮОМШӨ-ний даатгал	2,057.6	1,695.8
Ажилгүйдлийн даатгал	514.4	423.8
Эрүүл мэндийн даатгал	5,665.4	4,761.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	275,685.6	253,564.9
Гэрэл, цахилгаан	25,763.5	16,237.8
Түлш, халаалт	233,726.1	222,851.2
Цэвэр, бохир ус	16,196.0	14,476.0
Хангамж, бараа материалын зардал	49,049.7	44,462.6
Бичиг хэрэг	3,622.5	3,291.1
Тээвэр, шатахуун	30,376.0	27,113.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,656.1	5,097.4
Ном, хэвлэл	172.8	-
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,135.0	3,133.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,087.3	5,827.7
Нормативт зардал	119.2	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	119.2	-
Эд хогшил, урсгал засварын зардал	6,786.0	4,826.0
Урсгал засвар	6,786.0	4,826.0
Томилолт, зочны зардал	6,493.9	5,415.0
Дотоод албан томилолт	6,493.9	5,415.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,969.1	69,058.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,969.1	69,058.0
Бараа үйлчилгээний бусад зардал	71,391.3	6,110.3
Бараа үйлчилгээний бусад зардал	65,175.0	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,216.3	6,110.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	350,546.5	214,009.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	316,966.9	188,805.5
Засгийн газрын дотоод шилжүүлэг	316,966.9	188,805.5
Бусад урсгал шилжүүлэг	33,579.6	25,203.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,179.6	16,810.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,400.0	8,392.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,152,833.8	1,008,994.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	290,966.9
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	290,966.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,072,833.8	714,929.0
Орон нутгийн төсвөөс	781,866.9	714,929.0
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	290,966.9	-
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	80,000.0	3,099.0

Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	255.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,000.0	2,844.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	64,000.0	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	121,775.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	265,202.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,617.5
УРСГАЛ ЗАРДАЛ	58,617.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,473.8
Хангамж, бараа материалын зардал	1,938.0
Бичиг хэрэг	-
Тээвэр, шатахуун	1,908.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.0
Бараа үйлчилгээний бусад зардал	52,535.8
Бараа үйлчилгээний бусад зардал	52,535.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,143.7
Бусад урсгал шилжүүлэг	3,652.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,652.1
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	491.6
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	491.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,617.5
Нэмэлт санхүүжилтийн орлого	58,617.5
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,005.1
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,817.4
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,795.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(0.0)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,068.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,068.2 сая төгрөгийн алдааг залруулж ажиллалаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд зээлийн хүүгийн авлага 8.8 сая төгрөгийг тусгаагүй,
- Орлого үр дүнгийн нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны нийт орлогыг 258.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 61.0 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн,
- Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн санхүүгийн тайланд нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 159.8 сая төгрөгөөр, нийт цэвэр зарлагыг 249.8 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд засгийн газрын дотоод шилжүүлэг буюу орон нутгийн хөгжлийн сангийн зарлага 188.8 сая төгрөгийг тусгаагүй
- Орлогын гүйцэтгэлийн тайланд татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 141.4 сая төгрөгийг орлогын нэр төрлөөр салгаж тайлагнаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 46.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 20.5 сая төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 26.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

- Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг тооцоо судалгаанд үндэслээгүй, нийт төсвийн орлогын төлөвлөгөөг 8.7 сая төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3 "төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

- Захирамжийн дагуу хөрөнгө зарцуулсан боловч зарлагын анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажил гүйлгээний баримтууд тодорхой бус, "Баян хошуу багийн төвийн нээлт", "Ахмадын баяр" гэх мэт арга хэмжээнд нийт 11.8 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-д заасантай тус тус нийцэхгүй байна. хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх"-д заасантай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн хэрэгжилт, орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ИТХ-ын 2021 оны 3/01 дугаар тогтоолын дагуу малын тоо толгойн албан татварт ногдуулсан 2022 оны татварын орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай тухай хуулийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад холбогдох арга хэмжээг авч, төсвийн орлого бүрдүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 11 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд зээлийн хүүгийн авлага 8.8 сая төгрөгийг тусгаагүй,	1	8.8	1	8.8			1	8.8				
Орлого үр дүнгийн нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны нийт орлогыг 258.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 61.0 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн,	1	319.6			1	319.6	1	319.6				
Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн санхүүгийн тайланд нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 159.8 сая төгрөгөөр, нийт цэвэр зарлагыг 249.8 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан,	1	409.6			1	409.6	1	409.6				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд засгийн газрын дотоод шилжүүлэг буюу орон нутгийн хөгжлийн сангийн зарлага 188.8 сая төгрөгийг тусгаагүй	1	188.8	1	188.8			1	188.8				
Орлогын гүйцэтгэлийн тайланд татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 141.4 сая төгрөгийг орлогын нэр төрлөөр салгаж тайлагнаагүй байна.	1	141.4			1	141.4	1	141.4				
Дүн	5	1,068.2	2	197.6	3	870.6	5	1,068.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг тооцоо судалгаанд үндэслээгүй, нийт төсвийн орлогын төлөвлөгөөг 8.7 сая төгрөгөөр тасалсан байна.	1	8.7				8.7							
Захирамжийн дагуу хөрөнгө зарцуулсан боловч зарлагын анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажил гүйлгээний баримтууд тодорхой бус, "Баян хошуу багийн төвийн нээлт", "Ахмадын баяр" гэх мэт арга хэмжээнд нийт 11.8 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	11.8			1	11.8							
Сумын ИТХ-ын 2021 оны 3/01 дугаар тогтоолын дагуу малын тоо толгойн албан татварт ногдуулсан 2022 оны татварын орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	26.2					1	26.2					
Дүн	3	46.7			1	20.5	1	26.2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны мэдээлэлд 28 мэдээлэл хугацаа хоцруулж, аудитын дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны тайлан, төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, хөрөнгө зарцуулсан 47.8 сая төгрөгийн 4 шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 1 гүйлгээний 9.0 сая төгрөг, хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний 19.5 сая төгрөгийн 1 тендерийн ерөнхий мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.	1	76.3					1	76.3		
Дүн	1	76.3					1	76.3		

